



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын “Татан буулгах комисс байгуулах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 89 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой тус газрын баланст бүртгэлтэй хөрөнгүүдийг хүлээн авах, шилжүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Татан буугдсан байгууллагын хөрөнгийг хүлээн авч, холбогдох байгууллагад шилжүүлэх ажлын төлөвлөгөө болон холбогдох зардлын тооцоог гаргаж, тайланг 2023 оны 02 дугаар сарын 16-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2023 оны 01... дугаар сарын  
31... өдрийн А/... дугаар тушаалын хавсралт  
106

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Мөнхбаяр	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Н.Уранчимэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч
	Б.Амарзаяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хөрөнгө хариуцсан ахлах зохион байгуулагч
	Б.Сэргэлэнбаатар	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн байр ашиглалт, түрээс хариуцсан мэргэжилтэн
	Д.Батбаяр	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Нярав
	Э.Будханд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Аж ахуйн ажилтан
	О.Уранчимэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн Өмчийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн
	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн Төлөөлөл, менежментийн хэлтсийн Өмчийн менежмент хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэмөнх	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн Чингэлтэй дүүрэг хариуцсан мэргэжилтэн